

## Цахимжилтын эрин үеийн залуучуудын амьдралын зорилго, төлөвлөлт

**Баднаагийн Азбаяр, магистр**

*Шинжлэх Ухааны Академийн Философийн Хүрээлэн*

*Улаанбаатар, Монгол Улс, [azbayar@mas.ac.mn](mailto:azbayar@mas.ac.mn); <https://orcid.org/0009-0007-4737-8448>*

### Article history

Received : 2024-08-31

Accepted : 2024-09-20

Published : 2024-12-20

### Түлхүүр үгс

*нийгмийн хөгжил,*

*нийгмийн эрсдэл,*

*цахимжилт,*

*хэв маяг,*

*залуучууд*

**Хураангуй:** Залуучуудын хөгжил, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах асуудлын хүрээнд залуучуудын асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх, залуучуудад чиглэсэн төрийн бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах хэрэгтэй болж байна. Эдүгээ монголын залуучууд ямар нөхцөлд, хэрхэн амьдарч, юуг хүсэн мөрөөдөж, юуг зорилгоо болгож, түүндээ хүрэхийн тулд хэрхэн төлөвлөж, яаж хэрэгжүүлж буйг тодруулахыг энэхүү өгүүллээрээ гаргахыг хичээв. Сүүлийн жилүүдэд төрийн зүгээс залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлд ихээхэн анхаарч, бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор холбогдох төрийн байгууллага болон иргэний нийгэм, олон улсын байгууллага, мэргэжлийн байгууллага, хувь судлаачдын зүгээс энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ хийх нь нэмэгдэж байна. Төрөөс хийж байгаа судалгаанууд нь ихэвчлэн залуучуудын хөгжлийг дэмжих төрийн үйл ажиллагааг оновчтой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр голлон ажиллаж байгаа бол, судлаачдын хувьд залуусын нийгэм, эдийн засаг болон улс төрийн оролцооны талаарх судалсан нь элбэг байдаг. Үүний нэг нь залуучуудын хэрхэн төлөвшиж, хөгжиж байгаа, тэдэнд юу хэрэгтэй байгаа болон тэдний хэрэгцээ нь хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар сонирхон судлах эхлэл тавигдаж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, бодлогод тусгах, үйлчилгээ үзүүлэх чиглэлд ахиц дэвшил гарсныг зарим судалгааны үр дүнтэй харьцуулан үзсэнээрээ энэ өгүүллийн ач холбогдол оршино (Зөвлөх үйлчилгээний төсөл 2020, 3).

**Keywords**  
*social development,  
social risk,  
digitization,  
style, youth*

© The Author(s), 2024



## Objectives and plans for life for young people in the digital age

**Azbayar Badnaa** (MA)

*Institute of Philosophy, Mongolian Academy of Sciences*

*Ulaanbaatar, Mongolia, [azbayar@mas.ac.mn](mailto:azbayar@mas.ac.mn); <https://orcid.org/0009-0007-4737-8448>*

**Abstract:** In the context of the development of youth and the promotion of social and economic security, the best planning and implementation of measures to address youth problems must be given special attention, as well as the effectiveness of government policy towards youth. In this paper, I try to clarify conditions in which Mongolian youth live, dreams, goals, and how they plan and implement their goals. In recent years, as government attention has been paid to the direction of youth development and policy implementation, related government organizations, civil society, international organisations, professional organizations and individual researchers have conducted research and analysis in this direction. Government research focuses mainly on optimizing and improving the effectiveness of government activities to support the development of young people, but researchers often study young people's social, economic and political participation. One of them is the beginning of the interest in young people's growth and development, what they need, how they change their needs, and the progress made in solving problems, including them in policies and providing services is a benefit of this article (Consultancy Project, 2020).

### I. Оршил

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1991 оны 119 дүгээр зарлигийн хавсралтад 18-28 настай хүмүүсийг залуучууд гэж тодорхойлсон бол НҮБ-ын бодлогын түвшний бичиг баримтад 15-24 насны хүмүүсийг залуучууд гэж тэмдэглэжээ. Харин Залуучуудын хөгжлийг дэмжих хуулийн төслийн 3.1-д 18-35 насны хүмүүсийг залуус гэж тодорхойлсон байна (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем 2003). Манай улсын хөдөлмөрийн насны иргэдийн гуравны нэгээс илүү хувийг залуучууд эзэлж байгаа нь нийгэм эдийн засгийн хөгжилд тэдний үүрэг, оролцоо өндөр байгааг харуулж байна. 2023 оны байдлаар Монгол Улсад 15-34 насны залуучуудын тоо 1.011.958 хүрсэн бөгөөд энэ нь нийт хүн амын бараг гуравны нэгийг эзэлж байна (ҮСХ, 2023).

Судалж буй асуудлын ач холбогдол нь нийгмийг өөрчлөх, дижиталчлалын үйл явцын нөлөөн дор хөгжлийн шинэ шатанд шилжих явцад нийгмийн харилцааны бүх тогтолцоо шинэчлэгдэж бутай холбоотой. Энэ үйл явцын үр дүнд нийгмийн бүтэц, эдийн засаг, боловсролын харилцаа, үнэлэмжийн баримжаа, өдөр тутмын амьдралын хэв маягийн тогтолцоо харьцангуй шинэчлэгдсээр байна. Тухайлбал, залуучууд сурч боловсрон нийгмийн төлөвшилд хүрэх явцдаа дижитал хэрэглээний хамгийн идэвхтэй төлөөлөгч болохын хувьд өөрчлөгдөж буй эрсдэлт орон зайн нөлөөг зайлшгүй мэдэрдэг, цаашлаад энэхүү эрсдэлд өртөх тохиолдол цөөнгүй гарч буйг цахим дарамтын жишээн дээрээс харж болно. Залуучуудын дунд илэрч буй

цахимжилтын нийгмийн эрсдэлүүд нь олон талт байдал, харилцан хамаарлаар тодорхойлогдох болсон. Эдгээрийн дунд боловсрол, сургалт, эдийн засаг, чөлөөт цагаа өнгөрүүлэх зэрэг нь цахимжуулах үйл явцыг дагасан нийгмийн эрсдэлд хамгийн өртөмтгий байдлыг судлах зорилготой тодорхой жимээр холбогдож байна.

Улмаар залуучуудын хөгжилд чиглэсэн бодлого, үйл ажиллагаатай холбоотой судалгааг хийхдээ эрэмбэ дараа, ач холбогдлоор нь ангилж хийх нь зүйтэй байна. Эхний ээлжид залуучуудын зорилтот бүлэг, тэдгээрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон судалгааг хийж, түүнд үндэслэн залуучуудын үнэт зүйл, тэдний хэрэгцээ, амьдралын зорилго, төлөвлөлт, түүнийгээ хэрэгжүүлэх чиглэлээр авч буй арга хэмжээ, хандлагыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Нийгмийн тогтолцоонд залуучуудын хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлж, эргээд тэднийхээ хүчээр нийгэм нь хөгжиж байдаг зүй тогтлыг бүрдүүлэх шаардлагатай байгаа нь олон судалгааны үр дүн, эрдэмтэдийн санал дүгнэлтэд тусгалаа олсны зэрэгцээ дараах асуудлууд өнөөгийн залуучуудад тулгамдсан хэвээр буйн сацуу зохих шийдэл, гарцыг хүлээсээр байна.

Монголын нийгмийн хөгжлийн саад болсон ажилгүйдэл, ядуурлын дарамтыг шилжилтийн үеийн болоод өнөөгийн залуучуудын өмнө тулгарч буй гол асуудал болж байна. Үүнийг эдийн засгийн үүднээс Жон Мэйнард Кейнс ажилгүйдэл нь хүн амын худалдан авах чадварын сул байдал, түүний үр дүн (санхүүгийн хурц

асуудлыг үүсгэдэг) гэж тодорхойлсон байдаг. Социаль үүднээс ажилгүйдлийн ямар хэлбэр, хэв маяг зонхилж байна гэдгээс үл хамааран олон нийтийн ирээдүйдээ итгэх итгэл алдрах, гэр бүл сарних, гэмт хэрэгт холбогдох, эрүүл мэнд, соёл боловсролын үйлчилгээ авахад санхүүгийн боломж дутагдах асуудал бий. Угтаа хүн өөрийгөө хөгжүүлэх боломж хязгаарлагдмал болж, ядууралд өртөх, нийгмийн гишүүдээс хөндий байснаас сэтгэл зүйн дарамтанд орж, ганцаардах зэрэг социаль болон сэтгэл зүйн хүндрэлүүдтэй тулгарч байна. Ажил хайж буй хүн заавал хөдөлмөр зуучлалын албадаар дамжуулж цаг алдахгүйгээр хэвлэл мэдээлэл, холбоо харилцааны хэрэгслээр ажлын байрны тухай мэдээлэл авч, ажил олгогчтой биечлэн уулзаж ажилд орох боломж өдөр тутам нэмэгдэж байна (Баасантогтох О. 2009, 103).

Ажлын байрны хомсдолоос болоод олон мянган залуучууд амьдралын эрхээр эх орноо орхин, харийн нутагт хүнд хүчир хөдөлмөр эрхэлж байгаа. Мөнхүү тодорхой ажил, мэргэжлийн хүрээний оюунлаг залуус өөр оронд эрч хүч, авьяас чадвараа үнэлүүлэн амьдарч байгаа нь бас байна. Гадагш чиглэсэн залуучуудын нүүдлийг зөв буруу гэж дүгнэхээс илүүтэй цаашид эх орон нь энэ их нөөц баялгийг хэрхэн ашиглах, залуучууд өөрсдийн гэр бүл, үр хүүхэдтэйгээ элэг бүтэн аж төрөх, эх хэлээрээ зөв ярьж, эх соёл, түүхээ бүтээлцэх амьдрах цаг үеийг (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем 2003) төрийн зүгээс бүрдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах хэрэгтэйг судалгааны үр дүнгүүд харуулсаар ирсэн.

Үүнийг төр, засгийн зүгээс бодитоор тодорхойлох замаар улс орны болоод залуучуудын хөгжлийн алсын хараатай бодлогоор тусгаж, тэрхүү бодлогоо бодитоор хэрэгжүүлж үйл хэрэг болгох цаг нэгэнт болсныг энд тэмдэглэх нь зүйтэй хэмээн үзнэм. Залуучуудын үнэт зүйл ба амьдралын зорилго, төлөвлөлтийн тухайд “Залуучууд” гэдэг бол тухайн улс орны хөдөлгөгч хүч буюу гол бүтээлч хэсэг байдаг. Тэр ч утгаараа дэлхийн улс орнууд залуусаа хөгжүүлэх, тэднийг ажлын байраар хангах, амьдрах ая тухтай орчин бүрдүүлэхэд тогтвортой хөгжлийн бодлогоо чиглүүлдэг. Залуучуудын талаар төрөөс баримтлах бодлого нь аж ахуй эрхлэх зах зээлийн шинэ нөхцөлд дасан зохицсон, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвар бүхий, шинэ маягийн залуу хүнийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Монголын залуучуудын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхийн тулд “Монгол залуучууд” гэсэн хөтөлбөр боловсруулахыг санал болгосныг энд дурдах хэрэгтэй болов уу. 1990-ээд онд хөдөлмөрийн асуудлаар бие даасан судалгаа хийгдээгүй ч “Монголчуудын амьдралын хэв маягийн өөрчлөлт” сэдвийн хүрээнд хөдөлмөрийн харилцааны социологийн асуудал ямар нэг байдлаар хөндөгдсөн нь бий. Үүний гол жишээ бол амьдралын зорилго хөдөлмөрийн үйл ажиллагааны шинэчлэлд хөдөлмөрийн үнэлэмж баримжаалал, сэдэл, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрт хандах харилцаанд гарч буй өөрчлөлтийн асуудлыг авч үзсэн (Пүрэв Ц, Тэгшбаяр П. 2009) нь дээр дурдсан нөхцөл байдалд хийсэн нэг гол алхам гэж үзэж болно.

## **II. Судалгааны арга зүй**

“Беларусь, Монголын залуучуудын цахимжилтын нөхцөл дэх үүсэж буй эрсдэлт орон зайн агуулга, бүтцийг тодорхойлох” суурь судалгааны төслийн хүрээнд судалгааны ажил хэрэгжүүлж тоон болон чанарын арга ашиглав. Чанарын мэдээллийг ганцаарчилсан, фокус бүлгийн болон экспертний ярилцлага гэж хуваан авсан. Асуулгаар өнөө үед Монголын залуучуудын амьдралын зорилго, төлөвлөлт, ойлголт, тэдгээрийн харилцан хамаарал, өнөөгийн байдал зэрэг тодорхой асуудлын тодрууллаа. Түүнчлэн эрх зүйн баримт бичиг, статистикийн мэдээлэл, судалгааны тоон мэдээлэлд шинжилгээ хийж үр дүн гаргасан болно


## **III. Судалгааны үр дүн, хэлэлцүүлэг**

Монгол Улсын хувьд 2020 оны Дэлхийн залуучуудын хөгжлийн индексээр 181 орноос 58-д, 2021 оны олон улсын залуучуудын тогтвортой хөгжлийн индексээр 85 орноос 55-р байрт орсон байна. Залуу хүмүүс ихэвчлэн тохиромжтой ажлын байр олох гэж эрмэлздэг бөгөөд энэ нь ажилгүйдлийн түвшин өндөр эсвэл хангалттай санхүүгийн эх үүсвэргүй байдалд оруулж байдаг байна. Энэхүү санхүүгийн хангалтгүй байдал нь тэдний боловсрол, эрүүл мэнд, амьдралын сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж хувь хүний өсөлт хөгжилд хязгаарлалт, бэрхшээл болдог нь залуучуудын хамгийн их тулгамддаг асуудал юм. Нөгөө талаас залуучуудад өөрсдийн хүсэл эрмэлзэл болон тогтсон үнэт зүйлийн хандлага төлөвшөөгүй

байдаг нь ажлын байранд тогтвортой ажиллах байдлыг бууруулдаг байна. Энэ талаарх судалгаагаар хөдөлмөр эрхлэлтийн туршлага эрт бий болох нь залуус санхүүгийн мэдлэгтэй болохоос гадна тэдний нийгэмд оролцох оролцоонд эергээр нөлөөлдөг байна. Иймд залуусыг эрт бие даалгаж хувь хүн болгон төлөвшүүлэхэд хөдөлмөр эрхлэлтийн байдал чухал үүрэг гүйцэтгэдэг байна (МСН, 2023). Дээрх судлаачдын дэвшүүлсэн санааг дижитал талаас харвал дараах сонирхолтой дүр зураг ажиглагдаж байна. Дижитал төхөөрөмж нь хүмүүсийн өдөр тутмын үйл ажиллагааг бүртгэж, хувийн мэдээллийг цуглуулж, хадгалж, хувийн нууцад халдсан үед дижитал тандалт үүсдэг. Шинэ технологи хөгжихийн хэрээр 2010-2020 онуудад хүмүүсийг онлайнар хянах, ажиглах үйлдэл ихэссэн. Хувийн нууцад халдаж, зөвшөөрөлгүйгээр хүмүүсийг бүртгэж байгаа нь хүмүүсийг аюулгүй болгох ёстой технологийн хэрэглээнд эргэлзэхэд хүргэдэг. Мэдээллийн хадгалалт, тоон тандалтад хөндлөнгөөс оролцох нь хүний зан төлөвт нөлөөлдөг. Дижитал тандалтын сэтгэл зүйн үр дагавар нь хүмүүсийг байнга хяналтад байхаас санаа зовох, сэтгэл түгших, айдас төрүүлэхэд хүргэдэг (Хатанболд О, Цэцэнбилэг Ц, ба бусад 2024, 67) техник, технологийн

хөгжлийг дагаад дижитал хэрэглээ рүү нэвтрэх хандлагатай болжээ. Залуучуудын амьдралын зорилго, хэтийн төлөв байдал нийгмийн хөгжлөө дагаад өөрчлөгдөж байна. Ялангуяа интернэтийн хэрэглээ өсч буй энэ цаг үед амьдралын бүхий л нарийн ширийн асуудлаа социал орчинд амжуулах болсон. Энэ нь яах аргагүй амьдралын шинэ хэв маягийн нэгээхэн чухал салшгүй хэсэг болж байна. Цахим эрсдэлд ихэвчлэн өсвөр наснаас 35 хүртэлх насны иргэд өртөж байна гэсэн мэдээг олонтаа сонсогдож байгаатай холбогдуулан сүүлийн жилүүдэд интернэт орчинд зөв зохистой бөгөөд соёлтой оролцохыг хэн бүхэн уриалах болсон байна. Энэхүү уриалга нь цахим халдлага, цахим гэмт хэрэг, цахим эрсдлээс урьдчилан сануулах зорилготой юм. Сүүлийн жилүүдэд цахимжилтын үе ба шилжилтийн үеийн залуус гэж ихээхэн яригдах болсон. Энэ шилжилтийн үеийн залуучууд нийгмийн хөгжлөө дагаад төлөвлөлт сайтай болсон нь уг судалгааны дүнгээс харагдаж байна. Тэд нар боловсрол, хувь хүний хөгжил, мэдлэгээ дээшлүүлэх, ажил мэргэжлээ сонгох, гэр бүл зохиох гээд амьдралын бүхий л цаг үед төлөвлөлт зайлшгүй чухал хэмээн үзэж (Хатанболд О, Цэцэнбилэг Ц, ба бусад 2024, 67) үүнийгээ ч өөрсдийн амьдралдаа мөрлөг болгон хэрэгжүүлдэг.

Зураг 1. Залуучуудын амьдралын хэтийн зорилго төлөвлөгөөг дараах сегментээр харуулсан байдал



Дээрх 1-р сегментийн харьцуулалтаар өнөөгийн залуучууд амьдралынхаа хэтийн зорилгыг хэдийн тодорхойлсон бүлгийнхэн ажээ. Энэ залуусын амьдралын зорилго, чиглэлтэй, идэвхтэй бүлэгт

багтсан. Харин 2-р сегментэд амьдралын зорилгоо өөрчлөхөд бэлэн буюу эргэлзээтэй ханддаг нь илэрсэн бол, 3-р сегментэд амьдралын хэтийн зорилгоо тодорхойлоогүй залуучууд багтсан байна.

Зураг 2. Залуучуудын амьдралын зорилго, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд авах шаардлагатай арга хэмжээ



Залуучууд амьдралын зорилго, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд хэрэгтэй хүмүүстэй танилцах, ойр дотны хүмүүсийн зөвшөөрөл, дэмжлэг авах байдал нь хамгийн өндөр хувьтай гарсан бол мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, залхуурлаас ангид байх, цагаа үр бүтээлтэй өнгөрөөхийг боддог байх нь дээр хоёр үзүүлэлтээс бага байна. Эндээс үзвэл залуучууд өөрсдийн амьдралын зорилго, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ бусдаас хамааралтай байх хандлага байсаар буй нь ажиглагдаж байна.

Дээрх үр дүнг залуучуудын насны ангиллаар нарийвчлан үзвэл, судалгаанд хамрагдсан 18-32 насны залуучуудын хувьд амьдралынхаа зорилго, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мөн ирээдүйн амьдралынхаа зорилго, төлөвлөгөөг биелүүлэхийн тулд өөрт хэрэгтэй хүмүүстэй танилцдаг (16.6%), ойр дотны хүмүүсийн зөвшөөрөл,

дэмжлэг авдаг (15.30%) нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Энэ нь өнөөгийн залуучууд бусдын тусламж зөвлөгөөг авч хэрэгжүүлэх явдал нилээдгүй байгаа нь харагдаж байна. Түүнээс гадна, мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлдэг нь 13.70% байгаа нь өөрийн хүсэл тэмүүлээ даган илүү хөгжиж нийгэмд байр сууриа эзлэх, амьдралын төлөвлөгөөгөө боловсруулдаг гэж хариулсан явдал боломжийн төвшинд буйг илтгэнэ.

Судалгааны дүнгээр 18-32 насны хүмүүс өөрсдийн амьдралын зорилго, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд амьдрал ахуйдаа ихээхэн анхаарч байгаа. Энэ насны залуучууд хэрхэн амьдрал, ахуйдаа анхаардаг болохыг мөн хөдөлмөр эрхлэхэд ямар зүйлийг хамгийн их чухалчлан үзэж байгааг өнгөрсөн онд хийсэн судалгаагаар тодруулсан бөгөөд түүний үр дүнг дараах дүнгээс харж болно.

*Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг 1-5 хүртэлх баллаар хэмжсэн дундаж үзүүлэлт*

№		Хот	Хөдөө
1	Ахиж дэвших	4.3	4.3
2	Шинэ мэдлэг олж, сурч боловсрох	4.3	4.3
3	Ажлын цагийн уян хатан байдал	4.3	4.2
4	Бусдаас хараат бус байдал	4.2	4.0
5	Дуртай зүйлээ хийх	4.2	4.1
6	Орлогоо нэмэгдүүлэх	4.4	4.3
7	Татвар, даатгалын уян хатан байдал	4.1	4.1
8	Нийгмийн баталгаа, хамгаалал	4.1	4.1
9	Ажлын орчин	4.3	4.3
10	Хөдөлмөрийн нөхцөл	4.3	4.3
11	Аюулгүй байдал	4.3	4.3
12	Ажлын хамт олон	4.2	4.2
13	Олон нийттэй харилцаж олны дунд байх	4.1	4.1
14	Нэр хүнд	4.1	4.1
15	Ачаалал бага	4.1	4.0
16	Гэр бүлтэйгээ хамт байх	4.4	4.3
<b>НИЙТ</b>		<b>4.2</b>	<b>4.2</b>

18-32 хүртэлх насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд чухлаар тавигдах 1-16 хүчин зүйлийг шалгуур болгон үзэв. Дээрх дундаж утгаар харуулсан хүснэгт нь жигд тархалтыг харуулж байгаа бөгөөд хот болон хөдөөгийн залуус хөдөлмөр эрхлэхэд дээрх бүх хүчин зүйлсийг нэрлэж чухалд тооцсон байна.

Залуучууд чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлж буйг тодруулахын тулд дараах тодорхой нөхцөлийг авч үзэх хэрэгтэй болов уу. Жишээлбэл, баөмнөх таван жилийн хугацаанд хотын хөгжилтэй нийцүүлэн харахад амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх хүрээлэн буй орчны нөхцөл байдал сайжирсныг хэн хүнгүй харж байгаа гэдэгт найдаж байна. Нэгэн үе биеийн тамир спортыг хөгжүүлэхэд залуучуудын байгууллага хошуучлан оролцож их, дээд сургуулиар дамжуулан спортын шинэ төрлүүдийг дэлгэрүүлж түүнд залуучуудыг татан оролцуулах, тэдний спортын сонирхлыг татахад чухалчилж байв. Тухайн үед оюутан,

залуучуудын амьдралын хэв маяг, чөлөөт цагаа өнгөрүүлэх, хичээл номоо давтах, давтлага зөвөлгөө авах хэлбэр одоо үеэс өөр байсан нь тодорхой. Харин сүүлийн үеийн залуучуудын өдөр тутмын амьдралд интернэт тоглоом, баар цэнгээний газар, амралт зугаалгын бааз, худалдааны төв гэх мэт үйлчилгээний газрууд ихээр бий болсон нь нэг талаар залуучуудын амьдралын хэв маягт нилээдгүй өөрчлөлт орж, энэ утгаараа ч тэдний хандлага, сонирхол нилээдгүй өөрчлөгдсөн гэж болно. Залуучуудын эрүүл амьдралын хэв маяг нь хувь хүний хөдөлмөрийн болон нийгмийн идэвх, сэтгэл санааны тогтвортой байдал, ажиллах чадварын өсөлт зэрэг нийгэм соёлын таатай бичил орчинг бий болгодог. Цаашлаад эрүүл аж төрөх хэв маягт оюутны өөрийн эрүүл мэндийг сахин хамгаалахад чиглэгдсэн тодорхой үйлдлүүд ч мөн багтдаг (Мишээл А. 2013). Сүүлийн жилүүдэд энэ хэв маяг нь интернэт хэрэглээ болж өөрчлөгдөж буйг бид бүхэн бэлхнээ мэднэ.

Зураг 3. Залуучуудын амьдралд ажил, хөдөлмөр хэр ач холбогдолтой болох



Залуучуудын амьдралд ажил, хөдөлмөр эрхлэх нь хэр ач холбогдолтой болохыг тодруулахад, тэдний хувьд ажил, хөдөлмөр эрхлэх

чухал боловч түүнээс илүү хэрэгцээтэй зүйлс байна гэж 33 хувь, ажил бол миний хувьд амьжиргаа залгуулах арга хэрэгсэл гэж үзсэн нь 22.5 хувь, ажил



нь өөрөө ач холбогдолтой гэж 15.1 хувь нь, ажил бол өөрийгөө илэрхийлэх, зорьсондоо хүрэх боломж хэмээн 11.8 хувь, ажил бол тааламжгүй үүрэг, боломж байсан бол ажиллахгүй гэж 8.8 хувь, ажил бол бусадтай харилцах, олны дунд байх боломж (5.4%), ажил бол олны дэмжлэг, хүндэтгэлийг хүлээх боломж (4.5%) хэмээн тус тус хариулжээ. Үүнээс үзвэл, залуучуудад ажил, хөдөлмөр эрхлэх нь харьцангуй өндөр ач холбогдолтой байгаа хэдий ч цөөхөн хэд нь ажлаас чухал асуудал бас бий гэж үзэх хандлага буйг дээрх үр дүн харуулсан. Судалгааны хүрээнд хийгдсэн чанарын шинжилгээгээр “ажил бол аз жаргалтай, эд баялагтай амьдрахын гол үндэс”, мөн “нийгмийн байдаг л үзэгдэл учраас чухал ач холбогдолтой”, “нийгмийн үйл явц төдийгүй ажил хийхгүйгээр амьдрахгүй” (Философийн хүрээлэн, МУИС-ийн Улаанбаатар парк 2023) гэсэн хандлага, үзэл бодлын илэрхийлэл хамгийн түгээмэл байсныг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Судалгаанд хамрагдсан 18-32 хүртэлх насныхны хувьд энэ нь ажиллаж амьдрах үе бөгөөд ажил нь тэдний хувьд их үнэ цэнэтэй басхүү ач холбогдолтой болох нь судалгааны үр дүн баталж байна. Нөгөө талаас, ажил, мэргэжил чухал боловч түүнээс илүү үнэ цэнэтэй зүйл бол хувь хүний эрүүл мэнд, гэр бүлбайдаг болохыг залуус мөн онцолж байсныг дурдах нь зүйтэй. Түүнээс гадна залуучуудын дунд зан чанарын хувьд хичээнгүй, тууштай байдал зэрэг нь нэн тэргүүнд тавигдах ухал шаардлага, басхүү шинэ үеийнхэний эрүүл зөв хандлагын илэрхийлэл байгаад зогсохгүй ажил, хөдөлмөр бол сайхан амьдралын үндэс, нийгмийн том хэсгийг бүрдүүдэгч гэх байр сууринаас хандах явдал

залуучуудын дунд нийтлэг хэв маяг болсоор байна. Хэдийгээр судалгаанд оролцогч гэрлэсэн залуучуудын гэрлэлтийн сэтгэл ханамж өндөр байгаа ч, гэрлээгүй үлдсэн хэсэг нь гэрлэхэд төдийлөн яарахгүй байх хандлага ч нийтлэг ажиглагдсан.

Тухайлбал, судалгаанд хамрагдагсдын 70 гаруй хувь нь ямар нэгэн шалтгаангүйгээр ойрын хугацаанд гэрлэх бодолгүй байгаагаа ч мөн илэрхийлсэн нь сонирхол татахуйц зүйл мөн. Ийнхүү залуусын дунд ойрын хугацаанд гэрлэх бодолгүй байгаа хандлага нь судалгаанд оролцогчдын нас залуужих тусам илүү хүчтэй ажиглагдаж байсан юм. Учир нь эдийн засгийн боломж тааруу, цаг зав муутайгаас болоод гэрлэж чадахгүй байх тохиолдол 27-32 насныхны дунд түгээмэл үзэгдэл болсон байна. Судалгаанд оролцогчид нас харгалзахгүйгээр 40-50 орчим хувь нь 3 хүүхэдтэй болохыг хүсдэг боловч бодит байдал дээр хүүхдийн тоо хоёроос хэтрэхгүй байна. Харин 27-32 настай гэрлэсэн, хүүхэдтэй судалгаанд оролцогчдын 65 орчим хувь нь 2 хүүхэдтэй байгаа бол, 22-26 настай оролцогчдын 34 орчим хувь нь 2 хүүхэдтэй байв.

Энэ нь нэг талаас, гэрлэлт бол ажил албан тушаалд сайнаар нөлөөлөхөөс гадна удирдах албан тушаалд ажиллаж байгаа залуучуудын 75% нь гэр бүлтэй байгаагаас эл нөхцөл байдал батлагдаж байна. Өнөөгийн залуучуудын хувьд цалин бол тэдний орлогын гол эх үүсвэр байгаад зогсохгүй цалингийн хэмжээ нэмэгдэх тусам тэдний ажилдаа сэтгэл хангалуун байх байдал ч тэр хэмжээгээр нэмэгдэх боломжтой болохыг судалгааны дүн харуулсан юм. Үүнийг доорх зургаас дэлгэрэнгүй харж болохоор байна.

Зураг 4. Залуучуудын амьдралд ажил хэр зэрэг чухал байгааг хот, хөдөөгөөр харьцуулсан байдал



Судалгаанд хамрагдсан хотын залуучуудын 66.9 хувь нь ажил бол миний хувьд амьжиргаа залгуулах арга хэрэгсэл, 66.9 хувь нь ажил чухал боловч түүнээс илүү чухал зүйлс байгаа, ажил бол өөрийгөө илэрхийлэх, зорьсондоо хүрэх боломж гэж үзэж байгаа илэрхийлсэн байна. Харин хөдөө орон нутагт амьдардаг залуусын хувьд ажил бол тааламжгүй үүрэг, боломж байсан бол ажиллахгүй, ажил бол олны дэмжлэг, хүндэтгэлийг хүлээх боломж мөн бусадтай харилцах, олны дунд байх

боломж гэж үзсэн залуус 40-46%-ийн үзүүлэлтэй байна. Хотын залуусыг бодвол ажиллах идэвх сонирхол бага, ажил нь амьдралын гол чухал зүйлсийн нэг нь яах аргагүй ажил, хөдөлмөр эрхлэх мөн түүнээс өөр чухал зүйлс байдаг гэжээ. Хот суурин газар амьдарч байгаа залуусын хувьд ажил, хөдөлмөр эрхэлж гэмээ нь гэр бүлийнхээ өдөр тутмын хэрэгцээг хангах тул яах аргагүй тэдний амьдралын хамгийн чухал асуудал гэдгийг илэрхийлж буй билээ.

Хүснэгт 2. Таны амьдралд ажил ямар ач холбогдолтой вэ?

код		Хувь	Хот	Хөдөө
1	Өөрөө ач холбогдолтой, цалингаас хамааралгүйгээр	15.1	60.3	39.7
2	Ажил чухал боловч түүнээс илүү чухал зүйлс байна	33.0	62.9	37.1
3	Ажил бол миний хувьд амьжиргаа залгуулах арга	21.5	66.9	33.1
4	Ажил бол тааламжгүй үүрэг, боломж байсан бол ажиллахгүй	8.8	54.3	45.7
5	Ажил бол бусадтай харилцах, олны дунд байх боломж	5.4	58.1	41.9
6	Ажил бол олны дэмжлэг, хүндэтгэлийг хүлээх боломж	4.5	58.3	41.7
7	Ажил бол өөрийгөө илэрхийлэх, зорьсондоо хүрэх боломж	11.8	66.0	34.0
НИЙТ		<b>100.0</b>		

Залуучуудын амьдралын зорилго, төлөвлөлтийн нэг үндсэн асуудал бол

гэр бүл төлөвлөлтийн асуудал юм. БНХАУ-ын Жилиний Их сургуулийн

Философи, социологийн коллежид суралцаж эрдмийн зэрэг хамгаалсан доктор (Ph.D) П.Цэрэнбазар өөрийн зэрэг хамгаалсан бүтээлийн хүрээнд гүйцэтгэсэн “Улаанбаатар хотын залуучуудын гэр бүл төлөвлөлт” (2013) сэдэвт асуулгын судалгааны ажлын үр дүнгээр залуучуудын амьдралын хэв маягийн судалгааны хүрээнд 1980-1990 оны хооронд төрсөн, Улаанбаатар хотод амьдардаг, дээд боловсролтой залуучуудын гэр бүл төлөвлөлтийн асуудлыг нарийвчлан судлахыг чухалчилсан нь нэг талаас хөндөн буй сэдэв алс хэтдээ нилээд чухал зүйл болохыг илтгэсэн байдаг. Тэрээр мөнхүү судалгааны хүрээнд залуучуудын гэрлэлт, гэрлэлтийн сэтгэл ханамж, гэр бүл төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн сэтгэл ханамжийн асуудлыг гэрлэлтийн байдалтай холбож авч үзсэн нь ихээхэн сонирхолтой. (Цэрэнбазар П. 2013, 22-36) байна.

#### IV. Дүгнэлт

Монголын залуучуудын хөгжил, нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн асуудлаар өмнө нь хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын зарим үр дүндгүүдээс үзэхэд монголын залуучуудын цахим хэрэглээний хяналтын асуудалд зайлшгүй анхаарах шаардлага байгаа нь харагдаж байна.

Энэ цагийн монголын залуучуудын хэрэгцээ, амьжиргааны түвшин, ажил хөдөлмөр эрхлэлтэд глобальчлал, мэдээллийн технологи, эдийн засаг, бизнесийн хүчин зүйлийн нөлөөлөл их хүчтэй байгааг анхаарч залуучуудын ажилгүйдэл, ядуурал бууруулахад хотжилт, шилжих хөдөлгөөн, гадаад ажиллаах хүчний шилжих хөдөлгөөний асуудалд анхаарч зохицуулалт хийх хойшлуулашгүй

хэрэгцээ нэмэгдэж байна. Залуучуудын нийгэм, сэтгэл зүйд үзүүлж буй дотоод болон гадаад орчны нөлөөллийг тодорхойлох чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд тогтмолжуулах шаардлага тавигдаж байна.

Тодруулбал, залуучуудыг боловсролын чанар, түвшиний өөрчлөлт, боловсрол эзэмшилд гарч буй шинэ хандлагуудыг тогтмол ажиглах, онцлогийг тодорхойлох, тэдгээрийг төрийн аливаа бодлого, шийдвэрт анхаарч ажиллах хэрэгцээ, шаардлага өндөр байна.

Залуучуудын нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэхэд мэдээллийн ил тод, нээлттэй, үнэн бодитой, хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж, тэдэнд чиглэсэн аливаа үйл ажиллагааг төлөвлөх хэрэгжүүлэхэд залуучуудын санал бодлыг сонсох, тэдэнтэй зөвлөлдөх, оролцоог хангаж, залуучуудын хяналтыг бий болгох, тогтворжуулах асуудал чухлаар тавигдаж байна.

Мэдээллийн орчин үеийн технологийн хурдтай хэрэглээ нь мэдлэг, мэдээллийг цаг алдалгүй хурдан шуурхай авах бүрэн боломжтой ч, сул талууд их харагдаж байна. Мэдээллийн үнэн бодит байдал, хувь хүний мэдээллийг задлах, элдэв мэдээлэл оруулж, сэтгэл санааны хохиролд оруулах, залилан болон бусад төрлийн гэмт хэргийн хохирогч болдог байна.

Тухайлбал, архи, мансууруулах бодисоос хамааралтай залууст чиглэсэн сэтгэл зүй, эмчилгээний чиглэлээр баримтлах бодлого, зохицуулалт дутмаг байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн залуучуудын мэдээллийн технологийн болон

нийгмийн сүлжээний хэрэглээ, зан үйлийг тандах, тогтмол ажиглах, зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр бодлого, зохицуулалтыг сайжруулах, зөв хэрэглээний соёл, эерэг хандлага төлөвшүүлэх явдал өнөөгийн төр засгийн болоод хувь хүний цахим соёлын суурь шаардлага, ёс зүйн зохистой хэрэгцээ чухалд тавигдаж байна.

Цаашид Монгол залуучуудын цахим орон зайг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, судалгаанд суурилсан бодлого, шийдвэр гаргаж хэрэгжүүлэх хэрэгцээ нэн шаардлагатай байна. Орчин үеийн залуу хүнд үнэтэй, чанартай боловсрол олгодог, залуу хүний байр суурийг эцэг эхийн бэнчин, нэр нөлөө биш өөрийнх нь мэдлэг, боловсрол тодорхойлдог байхын тулд ажил мэргэжил, мэргэжлийн чиг баримжаа, ажил хөдөлмөрт зуучлах чухамхүү ямар үйлчилгээг хэрхэн үзүүлэх тал дээр анхаарах цаг болсон хэмээн үзэж байна.

## Ашигласан материал

- Зөвлөх үйлчилгээний төсөл. 2020. Залуучуудын хөгжлийг дэмжих нийтлэг үйлчилгээний стандарт боловсруулах. Улаанбаатар, 3.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. 2003. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг. Улаанбаатар.
- ҮСХ. 2023. Хүн амын тоо насны бүлгээр. <https://www2.1212.mn>.
- Баасантогтох О. 2009. *Философи, эрх зүйн судлал* XXIV: 103.
- Пүрэв Ц, Тэгшбаяр П. 2009. *Хөдөлмөрийн социологи*. Улаанбаатар.
- МСН. 2023. *Монгол залуучуудын нийгэм-сэтгэл зүйн өнөөгийн байдал, өөрчлөлт, хандлага*. Улаанбаатар.
- Хатанболд О, Цэцэнбилэг Ц, ба бусад. 2024. *Цахимжилтын нөхцөл дэх Монгол, Беларусийн залуучуудын нийгмийн эрсдэл*.

**Талархал:** Энэхүү өгүүлэлд ашигласан судалгааны суурь мэдээллийг түшиц бааз нь МУИС-ийн Шинжлэх ухааны технологийн Улаанбаатар парк, Бүгд Найрамдах Беларусь Улсын Үндэсний ШУА-ийн Социологийн хүрээлэнгийн хамтран хэрэгжүүлсэн “Беларусь, Монголын залуучуудын цахимжилтын нөхцөл дэх үүсэж буй эрсдэлт орон зайн агуулга, бүтцийг тодорхойлох” сэдэвт (ШУХТБ-2022/01) суурь судалгааны төслийн үр дүн болно. Тус өгүүллээр дамжуулан их, дээд сургуулиуд, шинжлэх ухааны байгууллага хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх ажлын хүрээнд ажиллаж буй нарийн мэргэшсэн судалгааны баг, төслийн удирдагч доктор (Ph.D) Цэцэнбилэг болон ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), ЭШТА О.Хатанболд нарт талархлаа илэрхийлье.

- ред. Цэцэнбилэг Ц, Хатанболд О. тех. редактор. Энхчимэг Б, Улаанбаатар: ШУТС, Философийн хүрээлэн, МУИС-ийн Улаанбаатар парк, “Тод бичиг” ХХК.
- Мишээл А. 2013. *Монгол хүний сэтгэлзүйн судалгаа 2013: Бид өөрчлөгдсөн болов уу?* Философийн хүрээлэн, МУИС-ийн Улаанбаатар парк. 2023. Беларусь, Монголын залуучуудын цахимжилтын нөхцөл дэх үүсэж буй эрсдэлт орон зайн агуулга, бүтцийг тодорхойлох (ШУХТБ-2022/01) сэдэвт суурь судалгааны төсөл. Улаанбаатар.
- Цэрэнбазар П. 2013. Улаанбаатар хотын залуучуудын гэр бүл төлөвлөлт. *Монголын хүн амын сэтгүүл*. 390: 22-36.